



**ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 15 дугаар зүйлийн 15.1.11, 16 дугаар зүйлийн 16.10, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.3, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.2, “Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017”, Эмнэлгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.4, 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.4, Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн хэмжээнд мөрдөгдөх “Эмнэлэгт үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, үйл явцын зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтаар баталсан журмыг нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж, хэрэгжүүлж ажиллахыг нийт тасгийн эрхлэгч нарт, удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (хурандаа Т.Нарантуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба (ахмад Ч.Өнөрсайхан)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан эмнэлгийн захирлын 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн А/53 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ,
ДЭД ХУРАНДАА



Х.БАТ-ИРЭЭДҮЙ

2023000218

Эмнэлгийн захирлын 2023 оны
02 дугаар сарын 13 ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЭМНЭЛЭГТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ЖУРАМ

ТТАХНЭ-Ж-ЭҮХЭ-03-118

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх, аюулгүй байдлыг хангах нийтлэг дэг, горимыг зохицуулахад оршино.
- 1.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ хуулийг дээдлэх, тэгш байдал, шуурхай хүртээмжтэй, чанартай, соёлтой байх зарчмыг баримтална.
- 1.3. Үйлчлүүлэгч хуулиар олгосон эрхийн хүрээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг авч, хуулийг дээдлэн, байгууллагын болон нэгжийн дотоод журмыг мөрдөж, бусдын эрх, эрх чөлөөг зөрчихгүй, соёлтой үйлчлүүлнэ.
- 1.4. Энэ журам нь эмнэлгийн нийт ажилтан, албан хаагч, хэвтэн эмчлүүлэгчид, тэдгээрийн сахиур болон ар гэрийнхэн, асран хамгаалагчдыг хамаарч үйлчилнэ.

Хоёр. Хэвтүүлэн эмчлэх шийдвэр гаргах, үйлчлүүлэгчийг хүлээн авах

- 2.1. Үйлчлүүлэгч бүр тус эмнэлгийн цахим бүртгэлд мэдээллээ үнэн зөв өгч бүртгүүлэн, амбулаторийн нарийн мэргэжлийн эмчид цаг захиалж, үзүүлэх бөгөөд яаралтай журмаар анх удаа ирж буй үйлчлүүлэгчийн бүртгэлийг Яаралтай тусламжийн тасагт хийнэ.
- 2.2. Амбулаторийн эмч үйлчлүүлэгчдэд бодит үзлэг хийж, шаардлагатай шинжилгээ, оношилгоонд илгээнэ.
- 2.3. Эмч үйлчлүүлэгчийн бодит үзлэг, шинжилгээ, оношилгоо дээр үндэслэн өвчний оношийг тавьж үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх, эсэх шийдвэрийг гаргана.
- 2.4. Эмч үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх шийдвэр гаргасан бол хэвтэх дараалалд бүртгэн авч (яаралтайгаас бусад тохиолдолд) хэвтэх өдрийг товлон, эмчилгээний тасагт хэвтүүлэн эмчлэх хүсэлтийг цахим байдлаар илгээнэ. Амбулаторийн эмч үйлчлүүлэгчид Ковид-19 өвчний түргэвчилсэн шинжилгээг хэвтэх өдрийн өглөө тус эмнэлэгт өгөх, хувийн бэлтгэлээ хангах, холбогдох дүрэм, журмын талаарх мэдээлэл, зөвлөмжийг өгнө.
- 2.5. Үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэхээр ирэхдээ:

- 2.5.1. Тэтгэвэрт гарсан болон нийгмийн халамж, группд байдаг хүмүүсээс бусад үйлчлүүлэгч өөрөө төлөх хамтын төлбөрийг төлөх;
 - 2.5.2. Ковид-19-н түргэвчилсэн шинжилгээний төлбөрийг төлөх;
 - 2.5.3. Тус эмнэлэгт хийгдээгүй, бусад эмнэлэг болон лабораторид өгсөн шинжилгээ, оношилгооны баримтуудыг эмчлэгч эмчид үзүүлэхээр авчрах
- 2.6. Дотор, мэдрэл, уламжлалт эмчилгээний тасгууд хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийг төлөвлөгөөт байдлаар долоо хоногийн Даваа, Лхагва, Баасан гаргуудад /нийтээр амрах баяр амралтын өдрөөс бусад/, Ерөнхий мэс заслын тасаг, Гэмтэл согог заслын тасаг, Хүүхдийн тасаг долоо хоногийн ажлын өдрүүдэд хүлээн авах ба үйлүүлэгчийг дараах үйл явцаар хүлээн авч, тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- 2.6.1. Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгч хэвтэх өдрийн 08 цаг 30 минутаас 09 цаг 30 минутын хооронд тус эмнэлгийн А, Б байрны хүзүүвч хэсгийн баруун талаар зоорины давхар /В1/-т ирж Ковид-19 өвчний түргэвчилсэн шинжилгээг өгнө.
 - 2.6.2. Түргэвчилсэн шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд зоорины давхраас эмнэлгийн Б байрны 1 дүгээр давхар луу гарна. Б байрны 1 дүгээр давхарт байрлах “Хувцас солих хэсэг”-т ирж эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчийн хувцас өмсөн, гадуур хувцсыг ар гэрийнхэнд буцаана. Үүний дараа “Нэг цэгийн үйлчилгээ-2”-т ирж өөрийн мэдээлэл, бар код бүхий бугуйвчийг зүүн эмчилгээний тасагт очно.
 - 2.6.3. Тасгийн эрхлэгч үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй урьдчилан танилцсан байх ба үйлчлүүлэгчийг ирэхэд цахим илгээх хуудсан дээр эмчлэгч эмч, өрөөг цохон хэвтэх зөвшөөрлийг баталгаажуулна.
 - 2.6.4. Тасгийн эрхлэгч баталгаажуулсны дараа Эдийн засаг, статистик, төлөвлөлтийн албанд мэдээлэн цахим өвчний түүхийн дугаарыг олгуулан баталгаажуулна.
 - 2.6.5. Ажлын цагаар яаралтай тусламжийн тасагт ирсэн үйлчлүүлэгчийг яаралтай тусламжийн тасгийн эмч үзэж, шаардлагатай оношилгоо, шинжилгээг хийлгэн, нарийн мэргэжлийн эмчид үзүүлж, хэвтүүлэн эмчлэх асуудлыг шийдвэрлэнэ.
 - 2.6.6. Ажлын бус цаг, амралтын болон баярын өдрүүдээр жижүүр эмч үзэн шаардлагатай оношилгоо, шинжилгээг хийлгэн оношийн тодруулан, хэвтүүлэн эмчлэх асуудлыг шийдвэрлэнэ.
 - 2.6.7. Яаралтай тусламжийн тасгаас хэвтүүлэн эмчлэх тасагт эмчлэхээр

шийдвэрлэсэн бол яаралтай тусламжийн тасагт өвчтөний мэдээлэл, эрсдэлийн стикер, бар код бүхий бугуйвчийг хэвлэн үйлчлүүлэгчид зүүж өгнө.

Гурав. Хэвтүүлэх эмчлэх тусламж үйлчилгээ

- 3.1. Үйлчлүүлэгчийг эмчилгээний тасагт ирэхэд ээлжийн сувилагч хүлээн авч, үйлчлүүлэгчийн эрсдэлийг үнэлэн, зохих өнгийн стикерийг бугуйвчинд нааж өгнө. Үйлчлүүлэгчид хэвтэх өрөөг зааж өгөн цагаан хэрэглэлийг олгоно. Хоол олгох цаг, хоолны өрөө, бугуйвчийн ач холбогдол, галын аюулгүй байдлын тухай болон сувилагч дуудах хонх, ариун цэврийн өрөөний хонхыг хэзээ, хэрхэн ашиглах талаар зөвлөгөөг өгч, эмчлэгч эмчийг танилцуулна.
- 3.2. Үйлчлүүлэгч өрөөндөө орж ор, шүүгээ зэрэг эд зүйлийг хүлээн авч, эмчийн үзлэгт биеэ бэлдэнэ.
- 3.3. Эмчлэгч эмч шинээр хэвтсэн үйлчлүүлэгчийг 13:00 цагаас өмнө үзэн, цахим түүхийг нээж, эмчилгээг заасан байна. Эмчлэгч эмч үйлчлүүлэгчид эмнэлгийн дотоод журмыг танилцуулан цахим өвчний түүхэн дээр гарын үсгээр нь баталгаажуулна.
- 3.4. Тасгийн сувилагч нар эмчилгээг 13:00-14:30 цагийн хооронд түүвэрлэн цахимаар тасгийн эрхлэгчид илгээнэ. Тасгийн эрхлэгч түүврийг хянан баталгаажуулна. Ахлах сувилагч баталгаажсан түүврийн хэвлэж, Санхүү хангамжийн албаны эм ,эмнэлгийн хэрэгсэл хариуцсан нягтлан бодогчоор санхүүгийн програмд зарлагын баримт болгон хэвлүүлж, зарлагын баримтыг Эм зүйн албанд хүргэнэ.
- 3.5. Эм зүйн албаны тухайн тасгийг хариуцсан жор баригч түүвэрлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийг захиалгын дагуу тасагт хүргэн ирж, өвчтөн тус бүрт тараана.
- 3.6. Тасгийн сувилагч 17:00 цагаас өмнө шинэ үйлчлүүлэгчийн эмчилгээг эхлүүлсэн байна.
- 3.7. Үйлчлүүлэгчийн биеийн байдал хүнд эсвэл хүндэвтэр байгаа тохиолдолд эмчлэгч эмч нэн даруй үзлэгийг хийж, эмчилгээг заан, эмчилгээг эхлүүлнэ.
- 3.8. Ажлын бус цаг болон амралтын өдрүүдээр жижүүр эмч үйлчлүүлэгчийн цахим өвчний түүхийг нэн даруй нээж, эмчилгээг тасгийн яаралтай хэрэглэгдэх эм тариа, эмнэлгийн хэрэгслээс сонгон зааж, эмчилгээг хийнэ.
- 3.9. Хэвтэн эмчлүүлэгчийг эмчлэхдээ эмч нар өвчний оношилгоо, эмчилгээнд баримтлах холбогдох хууль тогтоомж, дүрэм журам заавар, стандартыг баримтлан, ёс зүйн зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллана.

- 3.10. Төв болон тусгай эмнэлгээс нарийн мэргэжлийн эмч дуудан, зөвлөгөө авах тохиолдолд эмчлэгч эмч тасгийн эрхлэгчид танилцуулан, эмч дуудах хуудсыг бичиж Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлаар баталгаажуулж, эмчийг дуудна.
- 3.11. Эмчилгээний тасгууд хоорондоо болон эрчимт эмчилгээний тасагт үйлчлүүлэгч шилжүүлэх, эрчимт эмчилгээний тасгаас эмчилгээний тасагт үйлчлүүлэгчийг шилжүүлэх тохиолдолд Эмнэлгийн захирлын 2023 оны А/17 дугаар тушаал “Үйлчлүүлэгчийг тасаг хооронд болон бусад эмнэлэгт шилжүүлэх журам”-г мөрдөнө.

Дөрөв. Үйлчлүүлэгчийн мөрдөх журам

- 4.1. Үйлчлүүлэгч өрөө тасалгаандаа цэвэр, цэгцтэй байж, эмнэлгийн халдвар хамгааллын талаар эмч, эмнэлгийн мэргэжилтний өгсөн зөвлөгөөг даган биелүүлэх ба өрөөний эд хогшлыг ариг гамтай хэрэглэнэ. Хэрэв өөрийн буруутай үйлдлээс болж эмнэлгийн эд хогшлыг эвдэж, гэмтээсэн тохиолдолд үйлчлүүлэгч хохирлыг барагдуулна.
- 4.2. Үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх хугацаанд өөрийн хувийн эд зүйлийг хадгалж, хамгаалахад анхаарч, алдахаас сэргийлнэ. Хэрэв өөрийн буруутай үйлдлийн улмаас эд зүйлээ алдсан бол эмнэлэг хариуцахгүй.
- 4.3. Эмнэлгээс цагийн хуваарийн дагуу олгож байгаа эмчилгээний хоолыг зөвхөн хоолны өрөөнд иднэ.
- 4.4. Хүнд болон хэвтрийн үйлчлүүлэгчийн хоол, цайг үйлчлүүлэгчийн сахиур, сувилагч, хоол зөөгч нар үйлчлүүлэгчийн өрөөнд авчирч өгнө.
- 4.5. Үйлчлүүлэгчийн ар гэр Мягмар, Пүрэв гарагийн 14.00 цагаас хойш эмчлэгч эмчтэй уулзан өвчтөний биеийн байдал, шинжилгээ, оношилгоо, эмчилгээний талаар ярилцана. Яаралтай болон хүндэтгэн үзэх шалтгаанаар цаг харгалзахгүй уулзаж болно.
- 4.6. Үйлчлүүлэгч усанд орохдоо эмчээс зөвшөөрөл авч, ээлжийн сувилагчид мэдэгдэх бөгөөд унаж, халтирах зэрэг эрсдэлээс өөрийгөө хамгаалж, аюулгүй байдлаа хангана.
- 4.7. Үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэх хугацаандаа тасаг, нэгжээс зохион байгуулж буй эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамрагдана.
- 4.8. Галын аюул гарч “Улаан код” идэвхжүүлэх, газар хөдлөлт болон гамшгийн үед эмч, эмнэлгийн мэргэжилтний зааврыг дагаж мөрдөнө.
- 4.9. Үйлчлүүлэгч хувийн шалтгааны улмаас товросон хугацаанаасаа өмнө эмнэлгээс гарах тохиолдолд эмчлэгч /жижүүр/ эмчид албан ёсоор мэдэгдэн, цахим өвчний түүхийн өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах хүсэлтийг бөглөн,

хийгдээгүй байгаа үлдэгдэл эм тариаг тасгийн ахлах сувилагч /ажлын бус цагаар ээлжийн сувилагч/-д буцааж өгнө.

Тав. Сахиурын баримтлах журам

- 5.1. Биеийн байдал хүнд, хүндэвтэр болон эрсдэл бүхий үйлчлүүлэгчид сахиур, асран халамжлагч авах, эсэх талаар эмчлэгч эмч шийдвэр гаргаж, зөвшөөрөл олгоно.
- 5.2. Сахиур үйлчлүүлэгчийг сахихаар эмнэлэгт ирэхдээ Яаралтай тусламжийн тасагт Ковид-19 өвчний түргэвчилсэн тест өгч, сөрөг гарсан тохиолдолд хэвтүүлэн эмчлэх тасагт нэвтэрнэ. Тестийн төлбөрийг "Нэг цэгийн үйлчилгээ"-д төлсөн баримтыг яаралтай тусламжийн тасгийн сувилагчид өгч баталгаажуулна.
- 5.3. Эмчлэгч эмч үйлчлүүлэгчийн сахиурт үйлчлүүлэгчийн биеийн байдал, хооллолт, дэглэм, эмчилгээний талаар мөн эмнэлгийн дотоод журам, сахиурын журам, аюулгүй байдлын талаар танилцуулна.
- 5.4. Сахиурт зайлшгүй хүндэтгэх асуудал гарсан бол 1 удаа солигдохыг зөвшөөрнө.
- 5.5. Сахиур нь гадуур хувцсыг сольж цайвар өнгийн бэлтгэлийн хувцас өмсөнө.
- 5.6. Сахиурууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 5.6.1. Эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх журмыг мөрдөнө.
 - 5.6.2. Үйлчлүүлэгчийн хажууд байж эмчилгээ оношилгоонд явах, хооллох, бие засах зэрэгт туслах, сувилагчийг үйлчлүүлэгчид асаргаа хийхэд туслах
 - 5.6.3. Үйлчлүүлэгчийн байрлалыг солих
 - 5.6.4. Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг эмч, сувилагчид тогтмол мэдээлэх
- 5.7. Сахиуруудад дараах зүйлийг хориглоно.
 - 5.7.1. Үйлчлүүлэгчтэй цуг нэг орон дээр амрах
 - 5.7.2. Эмнэлгийн орчинд тамхи татах, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, сэлгүүцэх
 - 5.7.3. Үйлчлүүлэгчийн харгалзах хүнгүйгээр орхин явах
 - 5.7.4. Сахиур дур мэдэн солих
 - 5.7.5. Эмчлэгч эмчээс үйлчлүүлэгчид заасан дэглэм, хооллолтыг зөрчих
 - 5.7.6. Зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн талаарх мэдээ, мэдээлэл тараах, дуу, дүрс бичлэг хийхийг хориглоно.

Зургаа.Хэвтэн эмчлүүлэгчдийн мөрдөх цагийн хуваарь

№	Үйл ажиллагаа	Цаг	Тайлбар
1.	Өглөө босох, ороо засах	07:30	Хүнд, хэвтрийн үйлчлүүлэгчид хамаарахгүй
2.	Хувийн ариун цэвэр сахиx	07:30-08:00	
3.	Шинжилгээ өгөх	06:30-07:00	Шинжилгээ өгөх үйлчлүүлэгч нарт хамаарна
4.	Өглөөний цай	08:00-09:00	
5.	Эмчид үзүүлэх бэлтгэл	09:00-09:15	
6.	Эмчийн үзлэг орж, эмчилгээ хийлгэх	09:15-12:30	
7.	Өдрийн хоол	12:30-13:30	
8.	Өдрийн амралт	13:30-15:00	
9.	Эмчилгээ хийлгэх	15:00-18:00	
10.	Үдийн цай	16:00-17:00	
11.	Оройн хоол	18:00-19:00	
12.	Чөлөөт цаг	19:00-22:00	
13.	Унтах	22:00	

Эргэлт:

Ар гэр зөвшөөрөгдсөн зүйлсийг торонд хийн үйлчлүүлэгчийн овог, нэр, тасгийн хаягийг тодорхой, үнэн, зөв бичин нааж, хуваарийн дагуу Яаралтай тусламжийн тасгийн дэргэд байрлах шүүгээнд хийнэ.

Долоо: Хориглох зүйл

- 7.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтан, албан хаагчид дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:
 - 7.1.1. Үйлчлүүлэгчээс авлига, шан харамж авах, бэлэн мөнгө гар дээр Авахыг;
 - 7.1.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг зөрчихийг;
 - 7.1.3. Ажлын цагаар үйлүүлэгчийг дагуулж үзлэгийн кабинет, тасгаар явж эмч, эмнэлгийн мэргэжилтний ажил, үйлчилгээнд саад учруулахыг;
- 7.2. Үйлчлүүлэгчид дараах үйлдлийг хориглоно.
 - 7.2.1. Үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэх хугацаанд тамхи татах, архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх
 - 7.2.2. Бусад өрөө, палатаар хэсэх, тоглоом тоглох, чанга дуугаар ярих, орилж хашхирах бусад үйлчлүүлэгчийн тав тухыг алдагдуулах
 - 7.2.3. Энэ журмын 1 дэх хэсэгт заасан нэгдсэн хуваарийг зөрчих
 - 7.2.4. Үйлчлүүлэгч харшил өгөх, тарилга хийхэд саад болсноос бусад тохиолдол бугуйвчийг гарнаасаа авах

- 7.2.5. Зайлшгүй шаардлагатай оношилгоо, шинжилгээ хийлгэх зорилгоос бусад тохиолдолд эмнэлгийн А блок руу нэвтрэх
- 7.2.6. Үйлчлүүлэгч эмчийн зөвшөөрөлгүйгээр эмнэлгээс гарч явах, эм тариа дур мэдэн хэрэглэх, эмчилгээ хийлгэх
- 7.2.7. Тусгай өрөөнд хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч өрөөний түлхүүр авч явах
- 7.2.8. Эмнэлгийн дотоод журамд заасан болон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тавьсан хууль ёсны шаардлагыг зөрчих, биелүүлэхгүй байх
- 7.2.9. Үйлчлүүлэгч эмч, сувилагч, эмнэлгийн ажилчидтай хүндэтгэлгүй харилцах, хэл амаар доромжлох
- 7.2.10. Их хэмжээний мөнгө, үнэт эд зүйлс авч хэвтэх
- 7.2.11. Үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэх хугацаандаа эмнэлгийн автомашины зогсоолд машинаа тавих
- 7.2.12. Эмнэлгийн бус хувцас өмсөх, гадуур хувцас эмнэлэгт авч хэвтэх

Найм. Хариуцлага


- 8.1. Энэ журмыг зөрчсөн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 8.2. Энэ журмын хориглосон заалтыг зөрчсөн үйлчлүүлэгчийн эмчилгээг зогсоох, эмнэлгээс шууд гаргаж болно. Гаргасан зөрчлийн талаар үйлчлүүлэгчийн ажилладаг байгууллагад мэдэгдэнэ. Эмнэлгийн орчинд тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн тохиолдолд зөрчлийн талаар ажилладаг байгууллагад мэдэгдэнэ. Зөрчил гаргасан үйлчлүүлэгчид эмнэлгийн хуудас олгох эсэх асуудлыг эмнэлгийн захирал шийдвэрлэнэ.

Эмнэлгийн захирлын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Хэвтүүлэн эмчлэх үйл явцын зураглал

ТТАХНЭ-3- ХЭҮЯ-03-120



Эмнэлгийн захирлын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 4 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Хэвтэн эмчлүүлэх шийдвэр гаргах үйл явцын зураглал

ТТАХНЭ -3- ХЭШГҮЯ-03-119

